



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/400

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” 11/3477 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.18 дахь заалтад заасан “Тусгай хамгаалалттай газарт газар ашиглах” зөвшөөрөлгүйгээр 72 иргэн, аж ахуй нэгж байгууллага 55.8 га газарт үйл ажиллагаа явуулж байгаа нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.4 дэх хэсэгт заасныг зөрчсөнтэй холбогдуулан зохих арга хэмжээг авч, зөрчлийг арилгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунтуяа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүдэд: М.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

З.Ням-Очир (Алаг-Эрдэнэ сумын Засаг дарга)

А.Баттүшиг (Хатгал тосгоны захирагч)

Г.Энхбаяр (Хөвсгөлийн Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга)

Б.Эрдэнэдалай (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

З.Нямбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Улсын байцаагч)

Б.Энхмаа (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Э.Дэлгэрмөрөн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

П.Нямдорж (Алаг-Эрдэнэ сумын Газрын даамал)

Ч.Оюунгэрэл (Хатгал тосгоны газрын даамал)

6712010906

2.

Нарийн бичгийн дарга: Б.Ганзориг (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Х.Даваасүрэн (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Тусгай хамгаалалттай газарт газар ашиглах зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуй нэгж байгууллагын талаар холбогдох арга хэмжээг авч, зөрчлийг арилгуулж, хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

